ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 01 дүгээр сарын 21 өдөр Дугаар 03 Хэрлэн сум

III ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 03 дугаар хуралдаан 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 78,3 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, дархлаажуулалтын явц, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл танилцуулах,

Эрүүл мэндийн газар
Аймгийн ерөнхий тархвар судлаач

2.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үхрийн арьс товруутах өвчний санхүүгийн бичиг баримтын бүрдүүлэлтийн талаар танилцуулах, холбогдох зарим шийдвэр гаргах,

Мал эмнэлгийн газар
Санхүүгийн хяналт, аудитын алба

3.Улсын Онцгой комиссоос ирүүлсэн албан бичиг танилцуулах,

Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Төрийн болон аж ахуй нэгж байгууллагын дарга, сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1.Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх зорилгоор 0-5 настай хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчид цахимаар ажиллах нөхцөлөөр ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах,

Боловсрол, шинжлэх ухааны газрын даргыг тур орлон гүйцэтгэгч, Захиргаа, удирдлагын албаны ахлах мэргэжилтэн Ч.Ариунаа, сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.2.Ерөнхий боловсролын сургуулиудын амралтын хугацаанд сургуулийн эмч нарыг өөрөө зөвшөөрсөн тохиолдолд Коронавируст халдвар /Ковид-19/-аас

/ / М.Бадамсүрэн
/ / х/ч Б.Цогтбаяр

урьдчилан сэргийлэх, дархлаажуулалт, өрхийн эрүүл мэндийн төвийн үндсэн тусламж үйлчилгээний ажилд нэмэлтээр дайчлан ажиллуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.3.Дархлаажуулалтын нэмэлт сэргээх тунг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

1.4.Эмийн багц, оношлуурын нөөц бүрдүүлэх, түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдал, эрүүл мэндийн байгууллагын албан хаагч, боловсон хүчнийг оновчтой зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.5.Буяны ажлыг халдвар хамгааллын дэглэмийг сахиулж зохион байгуулах, хяналт тавих, олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн,
Эрүүл мэндийн шуурхай штабын дарга Ш.Ёл,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.6.Цагаан сарын баярын үед Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хяналт тавьж ажиллах талаар санал боловсруулж бэлтгэл ажлыг хангах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн,
Эрүүл мэндийн шуурхай штабын дарга Ш.Ёл-д:

1.7.Төрийн болон төрийн өмчит байгууллагын удирдлагуудад Цагаан сарын баяраар золголт хийхгүй байх талаар алба хаагч нарт ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах

/ / М.Бадамсүрэн
/ / х/ч Б.Цогтбаяр

Хоёр.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

2.1.Мал, амьтны гоц халдварт үхрийн арьс товруутах өвчний "Хорио цээрийн дэглэмийг цуцлах тухай" аймгийн Онцгой комиссын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж гаргах,

АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

2.2.Статистикийн хэлтэст дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах удирдамжийг боловсруулан гаргаж ажлыг зохион байгуулах, дүгнэлтийг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулах,

Гурав.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга, Малын өвчинтэй тэмцэх шуурхай штабын дарга Ч.Ганбат, Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн шуурхай штабын дарга Ш.Ёл нарт:

3.1.Улсын онцгой комиссоос албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу малын гоц халдварт өвчин, Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай чиглэлийг албан бичгээр сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт хүргүүлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, хурандаа Б.Бямбаа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

3.2.Сумын Онцгой комиссын ажлын албаны үйл ажиллагааг сайжруулах зөвлөн туслах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг цахимаар зохион байгуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.3.Хэрлэн сумын гэрээр тусгаарлагдаж буй иргэдийн гэрийн хяналтын үйл ажиллагаанд ашиглах зөөврийн хяналтын камер 10 ширхэгийг худалдан авах зардал 2,2 сая төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас гүйцэтгэгч байгууллагад олгохыг тус тус үүрэг болгов.

ДАРГА М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ Б.ЦОГТБАЯР

ТУ32095 0720030013 9029346